



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/383

Мөрөн сум

Барилга байгууламж ашиглалтад  
оруулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Ахмадын урлаг соёлын төвийн барилгын ажлыг хүлээж авах ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Энхжаргал

(Газрын харилцаа, барилга хот  
байгуулалтын газрын Барилга хот  
байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Х.Даваасүрэн

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө  
оруулалтын хэлтсийн мэргэжилтэн,  
Ерөнхий архитектор)

Г.Ням-Эрдэнэ

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн  
Сан хөмрөгийн эрхлэгч)

Д.Аюушжав

(Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын  
Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

Б.Гал-Эрдэнэ

(Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын  
Харилцаа холбооны хяналтын улсын  
байцаагч)

Д.Мягмарсүрэн

(Аймгийн Газрын харилцаа, барилга хот  
байгуулалтын газрын Барилга техник  
хяналтын улсын байцаагч)

С.Анхбаяр

(Аймгийн Онцгой байдлын газрын Гал  
түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад  
"Хөвсгөл эрчим хүч" ХХК-ийн Ерөнхий  
инженер)

Г.Даваадорж

("Хөвсгөл дулааны станц" ТӨХК-ийн  
Ерөнхий инженер)

Ш.Нямханд

("Хөвсгөл ус суваг" ХХК-ийн Ерөнхий  
инженер)

Д.Сүхээ

("Мэдээлэл холбоо сүлжээ" ХХК-ийн  
Ерөнхий инженер)

Ж.Лувсанням

6717010366



Ш.Баасанпүрэв	(Мөрөн сумын ЗДТГазрын дэд бүтэц, нийтийн тээвэр хариуцсан мэргэжилтэн, архитектор )
Зураг төслийн байгууллагын төлөөлөл: Н.Лхагважав	(“НАНУТО” ХХК-ийн Архитектор )
Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл: Д.Батсайхан О.Баяраа	(“Төгс үлэмжийн чанар” ХХК-ийн Захирал ) (“Төгс үлэмжийн чанар” ХХК-ийн инженер )
Ашиглагч байгууллагын төлөөлөл: Т.Ганбаатар	( Мөрөн сумын Ахмадын хорооны дарга )
Комиссын нарийн бичгийн дарга: Б.Баасанжав	(Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

2. Барилга байгууламжийн ажлыг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Барилга байгууламжийн ажлыг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Б.Баасанжав) -д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга байгууламж хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ

М.ХУЯГБААТАР

